



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/9/СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	12



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.03.13 № 292

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тодруулга тайланг материаллаг зүйлсийн хувьд стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520208



Үүрэг, хариуцлага

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандартуудтай нийцүүлэн түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ц.Дуламсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлого, зарлагын төлөвлөгөө батлуулах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.



Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын хог хаягдлыг зайлуулах.
- Нийтийн эзэмшлийн засвар үйлчилгээг хариуцах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн программ хангамж ашигладаггүй байна.

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд 8 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 28,002.2 мянган төгрөгөөс тооцон 280.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 292.0 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд орлогын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,725,9 мянган төгрөгөөр буюу 44,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,870.1	1,951.7	-1,918.4
Авлага	-	-	
Бараа материал	-	-	
Үндсэн хөрөнгө	184,116.1	339,066.1	154,950.0
Хуримтлагдсан элэгдэл	-22,859.6	-35,165.2	-12,305.6
Нийт хөрөнгө	165,126.6	305,852.6	140,726.0
Өр төлбөр	232.8	510.0	277.2
Хуримтлагдсан ашиг	164,893.8	305,342.6	140,448.8
Засгийн газрын оролцоо /ээдийн өмч/			
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	165,126.6	305,852.6	140,726.0

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаар хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь байгууллагад өгөх өр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 185,002.9 мянган төгрөгийн орлоготой, 44,554.1 мянган төгрөгийг зардалтай ажиллан, 140,448.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.



2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 73,757.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 1 зөвлөмж өгсөн нь хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд орлого, зарлагын батлагдсан төлөвлөөгүй 73,757.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Зориулалт бусаар зарцуулагдах
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг батлуулан ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 12 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3 870 134,79	1 951 658,59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3 870 134,79	1 951 658,59
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3 870 134,79	1 951 658,59
3121	Төгрөг	3 870 134,79	1 951 658,59
31213	Арилжааны банк дахь харилцах	3870134,79	1 951 658,59
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	161 256 516,45	303 900 902,86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	161 256 516,45	303 900 902,86
392	Биет хөрөнгө	161 256 516,45	303 900 902,86
39201	Барилга, байгууламж, орон сууц	62927000,00	62927000,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-524391,66	-1573175,00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	79800000,00	119800000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15960000,00	-23940000,00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	850000,00	0,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-779166,85	0,00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	615750,00	615750,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-278052,09	-341710,41
39214	Бусад үндсэн хөрөнгө	39923388,00	155723388,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5318010,95	-9310349,73
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	165 126 651,24	305 852 561,45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	232 840,00	510 000,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	232 840,00	510 000,00
413	Өглөг	232 840,00	510 000,00
4136	Бусад өглөг	232 840,00	510 000,00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/		510 000,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	164 893 811,24	305 342 561,45
51	Засгийн газрын хувь оролцоо	164 893 811,24	305 342 561,45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		0,00
512	Хуримтлагдсан үр дүн	164 893 811,24	305 342 561,45
51210	Өмнөх үеийн үр дүн	97224301,72	164893811,24
51220	Тайлант үеийн үр дүн	67669509,52	140448750,21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	165 126 651,24	305 852 561,45



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	105 929 187,40	185 002 892,60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	77 927 000,00	155 800 000,00
110	Орлогын албан татвар	77 927 000,00	155 800 000,00
1100	Хувь хүний орлогын албан татвар	77 927 000,00	155 800 000,00
110003	Хөрөнгийн орлого	77927000,00	155800000,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28 002 187,40	29 202 892,60
120	Нийтлэг татварын бус орлого	28 002 187,40	29 202 892,60
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	28002187,40	29202892,60
121002	Өмч хувьчлалын орлого	0,00	0,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	38 259 677,88	44 554 142,39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38 259 677,88	44 554 142,39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38 259 677,88	44 554 142,39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10 844 935,00	12 110 460,00
210101	Үндсэн цалин	10844935,00	12110460,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1 301 392,00	1 513 554,00
210201	Тэтгэврийн даатгал	1301392,00	1513554,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	666 444,00	302 376,00
210301	Гэрэл, цахилгаан	666444,00	302376,00
2104	Хангамж, бараа материалын зардал	2 675 600,00	9 275 250,00
210402	Тээвэр, шатахуун	2675600,00	9275250,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22 771 306,88	21 352 502,39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11209668,03	8196888,80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11561638,85	13155613,59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	67 669 509,52	140 448 750,21
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	67 669 509,52	140 448 750,21

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	28 002 187,40	29 202 892,60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28002187,40	29202892,60
120	Нийтлэг татварын бус орлого	28002187,40	29202892,60
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	28002187,40	29202892,60
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	21 465 199,03	31 121 368,80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21 465 199,03	31 121 368,80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21465199,03	31121368,80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10844935,00	12110460,00
210101	Үндсэн цалин	10844935,00	12110460,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1301392,00	1513554,00
210201	Тэтгэврийн даатгал	1301392,00	1513554,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	666444,00	302376,00
210301	Гэрэл, цахилгаан	666444,00	302376,00
2104	Хангамж, бараа материалын зардал	2675600,00	9275250,00
210402	Тээвэр, шатахуун	2675600,00	9275250,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5976828,03	7919728,80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5976828,03	7919728,80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6536988,37	-1918476,20
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1 536 988,37	(1 918 476,20)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2333146,42	3870134,79
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3870134,79	1 951 658,59



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			97 224 301,72	97 224 301,72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00	97 224 301,72	97 224 301,72
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
C07	Тайлант үеийн үр дүн			67 669 509,52	67 669 509,52
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	164 893 811,24	164 893 811,24
D01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0,00	0,00	164 893 811,24	164 893 811,24
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00	164 893 811,24	164 893 811,24
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0,00
D08	Тайлант үеийн үр дүн			140 448 750,21	140 448 750,21
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	305 342 561,45	305 342 561,45